



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Оны тэргүүний хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийг шагнаж, урамшуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, аргачлал”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны А/214 дүгээр тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийн дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ зохих ёсоор биелүүлэн, 2021 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хангаж ажилласан оны тэргүүний хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийг “Өргөмжлөл”, “мөнгөн шагнал”-аар тус тус шагнаж урамшуулсугай.

2. 2021 оны тэргүүний хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах мөнгөн хөрөнгийг зохих журмын дагуу олгохыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар /хурандаа С.Батбямба/-т зөвшөөрсүгэй.

4. Шагнагдсан хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжүүдийн удирдлага, бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, ажлын амжилт хүссүгэй.

5. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуул.

ДАРГА, ХУРАНДАА

Д.ЗАГДЖАВ



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын  
2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/14 дугаар  
тушаалын хавсралт

2021 оны ажил гүйцэтгэлээр шалгарсан хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар,  
хэлтэс, салбар нэгж, шийдвэр гүйцэтгэх тасаг

д/д	Эзэлсэн байр	Шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжийн нэр	Шагналын дүн /сая төг/
<b>“Хорих анги” төрөлд:</b>			
1	1 дүгээр байр	409 дүгээр хаалттай хорих анги	10.0
2	2 дугаар байр	421 дүгээр нээлттэй хорих анги	8.0
3	3 дугаар байр	427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	5.0
<b>“Хорих анги бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс” төрөлд:</b>			
4	1 дүгээр байр	Хэнтий аймаг дахь ШШГГ-419 дүгээр нээлттэй хорих анги	10.0
5	2 дугаар байр	Дархан-Уул аймаг дахь ШШГГ-445 дугаар нээлттэй хорих анги	8.0
6	3 дугаар байр	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГХ-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	5.0
<b>“Аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар” төрөлд:</b>			
7	1 дүгээр байр	Завхан аймаг дахь ШШГГ	8.0
8	2 дугаар байр	Дундговь аймаг дахь ШШГГ	6.0
9	3 дугаар байр	Баян-Өлгий аймаг дахь ШШГГ	4.0
<b>“Бусад салбар нэгж” төрөлд:</b>			
10	1 дүгээр байр	СМДӨАЭАХХГ	8.0
<b>“УТҮГ, ТӨААТҮГазар” төрөлд:</b>			
11	1 дүгээр байр	“Төр хур” УТҮГ	8.0
<b>“Нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тэргүүний хэлтэс” төрөлд:</b>			
12	1 дүгээр байр	Сонгино хайрхан дүүргийн Шийдвэр гүйцэтгэх 1 дүгээр хэлтэс	8.0
<b>“БХЗХТБА-ны тэргүүний тасаг” төрөлд:</b>			
13	1 дүгээр байр	Баянгол дүүргийн тасаг	8.0

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР